

Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр

А. ХЭЛЭЛЦЭЭРИЙН АГУУЛГА

▪ Энэхүү хэлэлцээрээр хоёр улсын иргэд Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсад шимтгэл төлж ажилласан давхардаагүй хугацаагаа нэгтгэн тооцуулж тэтгэвэр тогтоолгох, мөн тухайн улсад шимтгэл төлж ажилласан хугацаандаа ногдох тэтгэврийг шилжүүлэн авах нөхцөл бүрдэж, нийгмийн баталгаа нь хангагдах юм.

Б. ХЭЛЭЛЦЭЭРТ ХАМААРАХ ТЭТГЭВРИЙН ТӨРӨЛ

Дараах төрлийн тэтгэврийг Монгол Улс болон Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ:

Монгол Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Тэтгэврийн даатгалын сангаас олгох өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;
- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;

Бүгд Найрамдах Чех Улсаас авах тэтгэврийн төрөл:

- Өндөр насны тэтгэвэр, тахир дутуугийн тэтгэвэр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр;

Монгол Улсын иргэн дараах нөхцлийг хангасан тохиолдолд Бүгд Найрамдах Чех Улсаас тэтгэвэр тогтоолгон авах эрх үүснэ:

1. Бүгд Найрамдах Чех Улсад ажиллаж, шимтгэл төлсөн байх;
Үүнд Бүгд Найрамдах Чех Улсад 1995.12.31-ний өдрөөс өмнө Бүгд Найрамдах Чех Улсын их, дээд сургуульд суралцсан хугацаа орно;
2. Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжид заасан өндөр насны тэтгэврийн насанд хүрсэн байх;
3. Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжоор тогтоосон тэтгэврийн даатгалын шимтгэл төлж ажилласан байвал зохих хугацаа /30 жил/-г хангасан байх.

- **Бүгд Найрамдах Чех Улсын хууль тогтоомжийн дагуу тэтгэвэр тогтоох нас:**

Төрсөн он	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох нас
1960	64 нас 2 сар
1961	64 нас 4 сар
1962	64 нас 6 сар
.....	1 жил тутамд 2 сараар нэмэгдэнэ
1984 он ба түүнээс хойш	68 нас

- Шимтгэл төлж ажилласан байвал зохих 30 жилийн хугацаанд Монгол Улсад шимтгэл төлсөн хугацааг оруулан тооцно.

Бүрдүүлэх материал:

- Тухайн улсад ажиллаж байсан бол түүнийг нотлох өөрт байгаа аливаа бүх баримт бичиг;
- Суралцаж байсан бол дипломын хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар эсхүл лавлагаа